

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар А/816/218

**Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох
тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хоногт 50 шоо метрээс бага, аюултай бохирдуулах бодис агуулаагүй хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого, зохицуулалтын газар /Ш.Мягмар/, Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Лхагвацэдэн/-т тус тус даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН
САЙД Н.ЦЭРЭНБАТ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛА
САЙД

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан

2019 оны А/816/218 дугаар тушаалын хавсралт
Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын
жишиг хэмжээ

№	Үйлдвэр	Органик бодис (Химийн хэрэгцээт хүчил төрөгчөөр)-ын жишиг хэмжээ, кг/м ³
Нэг. Үйлдвэрлэл		
1	Талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн, гоймон	3.50
2	Чихэр, шоколад	2.50
3	Гурил, тэжээл	1.50
4	Ус, ундаа, жимсний шүүс	0.80
5	Дарс, шар айраг	5.00
6	Архи, спирт	8.00
7	Мах, махан бүтээгдэхүүн	2.50
8	Өлөн дайвар бүтээгдэхүүн, мал нядлах	5.00
9	Сүү, сүүн бүтээгдэхүүн	2.00
10	Жимс жимсгэнэ, ногоо, самар, ургамлын тос, амтлагч	1.50
11	Будах, цайруулах бодис хэрэглэдэггүй ноос, ноолуур угаах цех	8.00
12	Сүлжмэл, ээрмэл, оёдол	0.80
13	Эсгий, эсгий гутал	5.00
14	Мод боловсруулах, цаас, целлюлоз, картон	2.50
15	Тавилгын үйлдвэр	0.80

№	Үйлдвэр	Органик бодис (Химийн хэрэгцээт хүчил төрөгчөөр)-ын жишиг хэмжээ, кг/м ³
16	Хэвлэх үйлдвэр	1.50
17	Эм, эмийн бэлдмэл	3.50
18	Саван, үнэртэн, гоо сайхан, ариутгал, цэвэрлэгээний бүтээгдэхүүн, будаг, лак, цавуу	3.50
19	Эрчим хүч, дулааны үйлдвэрлэл	0.40
20	Үхэр, гахай, шувууны ферм	3.50
21	Хүлэмж	0.80
22	Бусад үйлдвэрлэл	0.80
Хоёр. Үйлчилгээ		
23	Хими цэвэрлэгээ	2.50
24	Угаалгын газар	0.80
25	Үзвэр, худалдаа, ахуйн үйлчилгээ	0.80
26	Нийтийн хоол	2.50
27	Автомашин угаалгын газар	2.50
28	Зочид буудал, жуулчны бааз, ажилчдын тосгон	1.50
29	Бусад үйлчилгээ	0.80
Гурав. Нийгмийн үйлчилгээ болон бусад		
30	Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, лабораториуд	2.50
31	Бүх шатны боловсрол, халамжийн байгууллагууд	0.80

